



USAID
FROM THE AMERICAN PEOPLE



Economic Policy Reform and
Competitiveness Project

ЭЗБШӨЧ ТӨСЛИЙН САР ТУТМЫН ЦУВРАЛ

2007 оны 10 дугаар сар

Монголын Банкуудын Холбоо зээлийн мэдээллийн санд туслалцаа үзүүлэх гэрээнд гарын үсэг зурлаа

ЭЗБШӨЧ төслөөс хувийн хэвшил давамгайлсан зээлийн мэдээллийн сан (ЗМС) байгуулахад туслалцаа үзүүлж эхэлснээс хойш хоёр жилийн дараа энэ оны 10 дугаар сарын 29-ний өдөр Монголын Банкуудын Холбоо (МБХ)-ноос Олон Улсын Санхүүгийн Корпораци (ОУСК)-тай техникийн туслалцааны гэрээнд гарын үсэг зурлаа. Гэрээний нөхцлийн дагуу МБХ, ОУСК нь техник, эдийн засгийн тооцоо судалгаа, бизнесийн төлөвлөгөө ба бизнесийн загварыг боловсруулахад гарах зардлыг тэнцүү санхүүжүүлэхээр болжээ.

Хувийн хэвшил давамгайлсан ЗМС байгуулах талаарх төслийн хүчин чармайлт хоёр жилийн өмнө Монголбанкттай



хамтран зохион байгуулсан уулзалтаас эхэлсэн бөгөөд хувийн хэвшлийн банк, санхүүгийн байгууллагууд оролцсон уг уулзалт дээр Монголбанкнаас ЗМС-г хувийн хэвшилд шилжүүлэхэд бэлэн байгаагаа мэдэгдсэн юм.

ЭЗБШӨЧ төслийн хувьд хувийн хэвшил давамгайлсан ЗМС-г байгуулах үйл ажиллагаанд 2005 оноос буюу 11-р сарын 2-ны өдөр Монголбанк, тус төсөлтэй хамтран *Зээлийн мэдээллийн сангийн ирээдүй* сэдэвт нээлттэй ярилцлага зохион байгуулсан өдрөөс оролцож эхэлсэн бөгөөд энэхүү ярилцлагад МБХ, арилжааны 13 банк, банк бус санхүүгийн 32 байгууллага, нийтийн аж ахуйн 4 компани оролцсон юм. Уулзалтын үеэр МБ-наас ЗМС-г хувийн хэвшилд шилжүүлэхэд бэлэн байгаагаа нээлттэй зарласан билээ.

Түүнчлэн 2006 оны 6 дугаар сарын 29-ний өдөр ЭЗБШӨЧ төсөл болон Монголбанкнаас хамтран сонирхогч талуудад зориулан нээлттэй ярилцлагыг дахин зохион байгуулж, уг ярилцлагад төслийн шугамаар урьж ирүүлсэн олон улсын мэргэжилтэн Рожер Най өөрийн хийсэн дүгнэлтийн талаар

дэлгэрэнгүй презентаци тавьсан юм. Тэрбээр ЗМС-г хувьчлах бэлтгэл ажлыг хангахад Монголбанкнаас зайлшгүй хийх шаардлагатай дараахь арга хэмжээний талаар зөвлөмж өглөө. Үүнд:

- Хэрэглэгчдийн санал гомдлыг барагдуулж шийдвэрлэхийн тулд харилцаа холбоог сайжруулах сүлжээ, программ хангамжийг суурилуулах бэлтгэл ажлыг хангах
- Хэрэглэгчдийн лавлагааны нэрлэсэн хураамжийг бий болгох
- Хувийн ЗМС-гийн эрх зүйн хувилбаруудыг судлах
- Шинэ байгууллагад тулгарч болох дараахь гол асуудлуудын талаар ярилцаж шийдвэр гаргахын тулд оролцогч талуудаас бүрдсэн ажлын хэсгийг хуралдуулах:
 - a) Оролцогч талууд болон гишүүнчлэлийн бүрэлдэхүүнийг тодорхойлох
 - b) Бизнес төлөвлөгөө боловсруулах
 - c) ЗМС-г хэзээ хувьчлахыг тогтох
 - d) Мэдээллийн аюулгүй байдал, хугацаа, нууцлал болон мэдээлэл авах баталгааг хангах
 - e) Сангийн үйл ажиллагааг эхлүүлэхэд дэмжлэг болох гадаадын техникийн туслалцааг авах.

Одоогийн ЗМС-гийн үзүүлж буй үйлчилгээг сайжруулах талаар гаргасан хувилбаруудыг хянан үзэх зорилгоор 2007 оны 2 дугаар сарын 28-ны өдөр МБХ-ноос төслийн дэмжлэгтэйгээр банкуудын удирдлагуудтай уулзалт зохион байгуулсан бөгөөд уг уулзалтад арилжааны 9 банк, банк бус санхүүгийн 2 байгууллага, МБХ-ны удирдлага, ЭЗБШӨЧ төслийн төлөөлөгчид оролцов. Төслийн зүгээс өнөөгийн байдалд хийсэн дүгнэлт, үйл ажиллагааны боломжтой чиглэлүүдийг танилцуулж ярилцсаны дараа хувийн хэвшлийн хяналт бүхий зээлийн мэдээллийн үйлчилгээ үзүүлэх компанийг байгуулах талаар Харилцан ойлголцлын санамж бичиг боловсруулах Ажлын хэсэг байгуулах саналыг санал нэгтэй зөвшөөрлөө. Үүний сацуу уулзалтад оролцогчид ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Монголбанк, Хас банк, Худалдаа, хөгжлийн банк, Капитрон банк, МБХ-ны төлөөлөл бүхий 5 гишүүнтэй байхаар тохиролцсон юм.

2007 оны 4-р сарын 10-ны өдөр МБХ, ЭЗБШӨЧ төслийн ивээл дор арилжааны 13 банк, банк бус санхүүгийн 3 байгууллагаас хувийн хэвшлийн хяналт бүхий зээлийн мэдээллийн үйлчилгээг үзүүлэх компанийг байгуулах тухай Харилцан ойлголцлын санамж бичигт гарын үсэг зурав. Энэхүү Санамж бичгийн хүрээнд байгуулагдах шинэ ажлын хэсэг нь дараахь ажлыг хийж гүйцэтгэх юм. Үүнд:

- Бизнес төлөвлөгөөг боловсруулах
- Монголбанкны дэргэд одоо үйл ажиллагаагаа явуулж буй Зээлийн мэдээллийг санг хувьчлах эсхүл зээлийн мэдээллийн хувийн шинэ сан байгуулах хувилбаруудын талаар стратегийн шийдэл бүхий зөвлөмж гаргах
- Хувийн хэвшлийн зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх эрх зүйн боловсронгуй хүрээг бий болгож хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдан хянах
- ЗМС-г хэн ашиглах, хэн түүний хувьцаа эзэмшигч байж болох талаар зөвлөмж гаргах
- Компаний бүтцийн талаар зөвлөмж гаргах

Энэхүү цувралд нийтлэгдсэн санал бодол нь АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлаг болон АНУ-ын Засгийн газрын байр суурийг илэрхийлээгүй болно.

- Техник болон санхүүгийн туслалцаа үзүүлэх стратегийн боломжит түншүүдтэй холбоо тогтоож, хэлэлцээ хийх.

ЗМС-гийн бүтцийн асуудлаар ОУСК-аас техникийн тусгай дэмжлэг үзүүлнэ гэж төслийн зүгээс найдаж байсан бөгөөд 2007 оны 4 дүгээр сард ОУСК-ийн Олон улсын Зээлийн сангийн баг Монголд зочилсон билээ. Ажлын хэсэг, томоохон банкууд болон Монголбанкны удирдлагуудтай хэд хэдэн удаа уулзан ярилцаж, оролцогч талуудад презентаци тавьсны үр дүнд ОУСК-ийн баг, Ажлын хэсэг болон ЭЗБШӨЧ төслийн зүгээс хувийн хэвшлийн зээлийн мэдээллийн санг хөгжүүлэх чиглэлээр хамтран ажиллах зарчмын хувьд тохиролцсон болно.

ОУСК-тай байгуулсан энэхүү зөвлөх үйлчилгээний гэрээний дагуу гарах зардлыг тэнцүү хуваан санхүүжүүлэхээр тохирсны үндсэн дээр ОУСК-аас ажлын хэсэгт зохих техник технологийн борлуулагч болон үйл ажиллагааны түншийг сонгох зэрэг зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагаатай холбоотой асуудлуудаар техникийн туслалцаа үзүүлэх юм. Нөгөө талаас ЭЗБШӨЧ төсөл нь хувийн хэвшил давамгайлсан ЗМС-г байгуулах боломжийг бүрдүүлэхэд тус дөхөм болох хууль тогтоомж, дүрэм журмыг боловсруулах талаар цаашид үргэлжлүүлэн ажиллах болно.

МБХ-ны хуулийн мэргэжилтнүүд болон ЭЗБШӨЧ төслийн шугамаар ирсэн зээлийн мэдээллийн сангийн олон улсын эксперт ноён Рожер Най-гаас бүрдсэн баг санал болгож буй зээлийн мэдээллийн хувийн хэвшлийн шинэ сангийн эрх зүйн хүрээний талаар гаргасан өөрсдийн санал, зөвлөмжийг энэ оны 5 дугаар сарын 14-ний өдөр танилцууллаа. Уг презентацид орчин үеийн зээлийн мэдээллийн сангийн зарчмуудыг хөхиүлэн дэмжиж буй ЗМС-гийн тухай шинэ хуулийн төслийн талаар танилцуулснаас гадна одоогийн мөрдөж буй холбогдох хуулиудад оруулах нэмэлт өөрчлөлтүүдийн талаар танилцууллаа.

МБХ, ОУСК-ийн хооронд байгуулах техникийн туслалцааны гэрээнд гарын үсэг зурах бэлтгэл ажлын хүрээнд ОУСК-ийн зээлийн сангийн мэргэжилтэн 2007 оны 10 дугаар сард МБХ-ны ЗМС-г байгуулах ажлын хэсэгтэй хамтран ажиллаж, техник эдийн засгийн тооцоо, судалгаа хийх мөн бизнесийн төлөвлөгөө боловсруулах чиглэлээр хийх ажлыг тогтоолоо.

Ирэх саруудад ОУСК, ЭЗБШӨЧ төсөл ба МБХ өөрсдийн хийж буй ажлуудыг нягт уялдуулан зохицуулах болно. Энэ хугацаанд төслийн зүгээс хувийн хэвшлийн ЗМС-гийн эрх зүйн болон зохицуулалтын хүрээг бий болгоход техникийн туслалцаа үзүүлэх бөгөөд ОУСК нь бизнесийн төлөвлөгөө, бизнесийн бүтцийн асуудлаар ажиллах болно.

Тээвэр зуучийн компаниуд Улаанбаатар хотод байгуулах ложистик төвүүдийн байршлын талаар Улаанбаатар Төмөр зам, хотын удирдлагатай уулзаж ярилцав

“Транзит Монгол” Үндэсний хорооны энэ оны 9 дүгээр сарын 25-ны өдөр хийсэн техникийн уулзалтын үеэр тохиролцсоны дагуу тээвэр зуучийн компаниуд, Улаанбаатар Төмөр зам (УБТЗ)-ын удирдлагууд ЭЗБШӨЧ төслийн 10 дугаар сарын 5-ны өдөр уулзаж, Улаанбаатар хотын төмөр замын дагуу байгуулах ложистик төвүүдийн байршлын талаархи төлөвлөгөөг хэлэлцэв. Улаанбаатар Төмөр замын Хүний нөөц, нийгмийн асуудал хариуцсан орлогч дарга ноён Л. Халтар даргалсан уг уулзалтад дараахь хүмүүс оролцлоо. Үүнд:

- Я. Эрхэмбаяр, Эрин интернейшнл ХХК-ий захирал
- В. Пүрэвчулуун, Туушин ХХК-ий орлогч захирал
- Д. Энхээ, Трансгэйт ХХК-ий гүйцэтгэх захирал

- Ц. Елена, ТММ ХХК-ий ерөнхий менежер
- Б. Батхүү, Монгол Экспресс ХХК-ий Бизнес хөгжлийн менежер
- А. Ганбат, МН Ложистик ХХК-ий захирал
- П. Солонго, Азийн зам ХХК-ий ерөнхий менежер
- Д. Насанбат, Трансгэйт ХХК-ий орлогч захирал
- П. Батхуяг, Олон Улсын Тээвэр Зуучлалын төвийн ерөнхий захирал



- Б. Энх-Амгалан, Таван Богд ХХК-ий ерөнхий захирал
- Д. Буяншиг, ВЛС ХХК-ий захирал
- М. Батцэрэн, ВЛС ХХК-ий ерөнхий менежер

Энэхүү уулзалтаар тээвэр зуучийн салбарын өмнө тулгамдаж буй асуудлууд мөн Улаанбаатар, Замын-Үүдэд ложистикийн терминал төвүүдийг байгуулах хэрэгцээ шаардлага, бэлэн байдал гэх мэт гол асуудлуудыг хэлэлцэв.

Уулзалтад оролцогчид ложистикийн төвийг байгуулах ач холбогдлын талаар санал нэгдэж, эдгээр төвүүдийн өмчлөл ба менежментийн талаархи зарим хувилбарыг авч хэлэлцэв. Хотын мастер төлөвлөгөөнд оруулж буй нэмэлт өөрчлөлтүүд хөрөнгө оруулалт хийх шийдвэрт нөлөөлөх тухай уулзалтад оролцогчид онцлон тэмдэглээд төслийн зүгээс хотын удирдлагатай уулзалт зохион байгуулж өгөхийг хүслээ.

Үүнээс гадна тээвэр зуучийн компаниуд, Улаанбаатар хотын захиргаа ба ЖАЙКА-гийн Улаанбаатар хотын Тээврийн техникийн баг оролцсон уулзалт 10 дугаар сарын 11-нд АНУ-ын ОУХА-ийн Сургалт, мэдээллийн төвд болж, хотын захиргааг төлөөлөн Хотын хөгжлийн бодлогын газрын дарга Б.Мөнхбаатар, “Улаанбаатар хотын мастер төлөвлөгөө болон хот байгуулалтын хөтөлбөр” дээр ажиллаж буй ЖАЙКА-гийн ахлах мэргэжилтнүүд оролцов. Уулзалтад дараахь хүмүүс оролцлоо. Үүнд:

- Кенжи Маруока, ЖАЙКА-гийн Судалгааны багийн удирдагч, Зам төлөвлөлтийн мэргэжилтэн
- Д. Хашбат, ЖАЙКА-гийн Судалгааны баг, Тээвэр төлөвлөлтийн мэргэжилтэн
- В. Пүрэвчулуун, Туушин ХХК-ий орлогч захирал
- Д. Энхээ, Трансгэйт ХХК-ий гүйцэтгэх захирал
- Б. Батхүү, Монгол Экспресс ХХК-ий Бизнес хөгжлийн менежер
- А. Ганбат, МН Ложистик ХХК-ий захирал
- П. Солонго, Азийн зам ХХК-ий ерөнхий менежер
- Д. Насанбат, Трансгэйт ХХК-ий орлогч захирал
- П. Батхуяг, Олон Улсын Тээвэр Зуучлалын төвийн ерөнхий захирал
- Б. Энх-Амгалан, Таван Богд ХХК-ий ерөнхий захирал
- Д. Буяншиг, ВЛС ХХК-ий захирал

- М. Батцэрэн, BLC ХХК-ий ерөнхий менежер
- Я. Эрхэмбаяр, Эрин интернейшнл ХХК-ий захирал

Улаанбаатар хотын төлөвлөлт ялангуяа эдийн засгийн хувьд дахин бүсчлэх асуудлын талаар хотын захиргааны төлөөлөгч танилцуулж, дахин бүсчлэх боломж түүний ложистикийн төвүүдийг байгуулахад оруулах хөрөнгө оруулалтад үзүүлэх үр нөлөөний талаар ярилцаж санал бодлоо солилцов.

Улаанбаатар хотын захиргаанаас газрын бүсчлэлийн асуудлыг шийдвэрлэх, ложистик төвүүд ба бөөний худалдааны бизнест ашиглах мөн ложистик төвүүдийг төмөр замын дагуу байгуулах тухай шийдвэр гаргахдаа хувийн хэвшлийг оролцуулах талаар УБТЗ, хотын захиргаа болон тээвэр зуучийн компаниудын хооронд үргэлжилж буй асуудлаар харилцан тохиролцлоо.

Газрын бүсчлэл, ашиглалт болон төмөр замын дагуу байгуулах ложистик төвүүдийн талаар шийдвэр гаргах хүртэл хөрөнгө оруулалт хийх боломжгүй тухайгаа тээвэр зуучийн компаниуд мэдэгдэж, гэхдээ эдгээр асуудлаар шийдвэр гаргах үйл ажиллагаанд оролцох хүсэлтэйгээ илэрхийлсэн юм.

Худалдааны бодлогын судалгааны ажлын шалгаруулалтад оролцогсдод тэтгэлэг гардуулах ёслолын ажиллагаа

Үйлдвэр худалдааны яам (ҮХЯ), Германы Техникийн Хамтын ажиллагаа (GTZ), АНУ-ын ОУХА-аас санхүүжиж буй ЭЗБШӨЧ төслийн төлөөлөгчдөөс бүрдсэн шагналын хорооноос судалгааны 5 ажлыг шалгаруулж, тэтгэлэг гардуулах арга хэмжээ ҮХЯ-нд 10 дугаар сарын 23-ны өдөр боллоо.

ҮХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга Б. Нямсүрэн, ЭЗБШӨЧ төслийн удирдагч Фернандо Бертоли, ГТХА-ны зохицуулагч Альберт Геренд нар шалгарсан судалгааны ажлын эздэд баяр хүргэж, тэтгэлгийн урьдчилгааг гардууллаа. Тэтгэлгийн үлдэх хэсгийг судалгааны ажил амжилттай дууссаны дараа олгох юм. Өмнө нь зохион байгуулсан Худалдааны зуны сургалт семинарт оролцогчдоос Монгол Улсын худалдааны



бодлогын чиглэлээр хийсэн судалгааны ажлыг шалгаруулах саналыг АНУ-ын ОУХА-аас санхүүжиж буй ЭЗБШӨЧ төсөл ба ГТХА-аас дэмжиж, шалгарсан судалгааны ажлын эздэд олгох тэтгэлгийг хамтран гаргаж зохион байгуулсан болно. Худалдааны зуны сургалт семинар нь Монгол Улсын мэргэжлийн боловсон хүчний эдийн засаг, санхүүгийн судалгаа хийх ур чадварыг дээшлүүлэхэд чиглэсэн хоёрдахь удаагийн арга хэмжээ байсан юм. Санхүү, эдийн засгийн

чиглэлээр хийсэн анхны зуны сургалтыг 2006 оны 7-8 дугаар сард жуулчны гэр баазад зохион байгуулсан.


Яам, агентлагуудын вэбмастеруудад зориулсан сургалт АНУ-ын ОУХА-ийн Сургалт, мэдээллийн төвд боллоо

ЭЗБШӨЧ төсөл Мэдээлэл, харилцаа холбооны технологийн газар (МХХТГ)-тай хамтран Жуумла!Монгол агуулгын удирдлагын системийн 1.0 хувилбарыг албан ёсоор гаргаж байгаатай холбогдуулан, мөн мэдээллийн технологи (МТ)-ийн аюулгүй байдлын үндсэн зарчмуудын талаар 4 өдрийн практик сургалт зохион байгуулав. Энэ хувилбарыг хамгийн сүүлд сайжруулсан Жуумла!Монгол 1.0.13 хувилбарт



суурилуулан боловсруулсан ба өнгөрсөн 6 дугаар сард гарсан бэта хувилбараас олж илрүүлсэн хэд хэдэн хүндрэлтэй асуудлуудыг засч шийдвэрлэн түүний, найдвартай ажиллагааг баталгаажуулсан юм.

Энэ оны 10 дугаар сарын 25-30-ны өдрүүдэд болсон сургалтад 8 яам, 25 агентлагийн 51 вэбмастер, сүлжээний администраторууд оролцсоны дотор Булган, Орхон, Дархан-Уул аймгийн татварын газрын төлөөлөгчид байв.



Сургалтад оролцогсод дараачийн төлөвлөгөөт сургалтад оролцохын өмнө энэхүү сургалтын үеэр заасан арга ажиллагаа, техникийг ашиглан өөрсдийн мэдээллийн системийн аюулгүй байдалд аудит хийсэн байх юм. Дараагийн сургалтаар зардал багатай, зохих шийдлүүдийн хувилбаруудын талаар танилцуулж хэрэгжилтийн талаар ярилцах болно.

Шаардлагатай шийдэл, түгээмэл хэрэглэгддэг аргуудын талаар мэдлэг хомс буй байдал нь төрийн байгууллагуудын вэбсайтын аюулгүй байдал, үйл ажиллагааг эрсдэлд оруулж, иргэдэд төрийн мэдээлэл хүргэх, тэднийг олон нийтийн хэлэлцүүлэгт оролцуулах хүчин чармайлтыг сулруулж байна. Вэбмастеруудад вэбсайтаа дахин шинэчлэх, байгууллагынхаа мэдээллийн системийн аюулгүй байдлыг хянахад туслах

үүднээс дараагийн сургалтуудыг техникийн зөвлөгөө өгөх хэлбэрээр зохион байгуулахаар бэлтгэж байна. Туршилтын вэбсайтууд дээр ажиллаж, аюулгүй байдлын талаар бодит жишээн дээр суралцсан нь сургалтанд хамрагсдын сэтгэлд нийцэж, тэднээс өндөр үнэлгээ авсан юм.

Энэхүү цуврал нь ЭЗБШӨЧ төслийн үйл ажиллагааны тухайн сар тутмын цахим хэвлэл юм. Та өөрийн санал бодол, манай цувралыг захиалах буюу захиалгаа цуцлах хүсэлтийг ЭЗБШӨЧ төслийн цувралын эрхлэгчид дараах хаягаар ирүүлнэ үү.
И-мэйл fbertoli@epc-chemonics.biz, факс: (976-11) 32 78 25.